

МОНГОЛ СЕКЮРИТИЕС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2012 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Г “Монгол секюритиес” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн

ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.1 дахь заалтууд, Санхүүгийн Зохицуулах хорооны 2016 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 244 дүгээр тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих” журмыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 13.00 цагт Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8 дугаар хороо, Энх-тайваны өргөн чөлөө, “Хорин хоёр дугаар бааз” ХК-ийн байрны 201 тоотод хуралдуулахаар тогтоосугай.

2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар доор дурьдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай.

1. Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт;
2. Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах
3. Бусад

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2017 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөр тогтоосугай.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тухай зарыг өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр 2017 оны 03 дугаар сарын 17-ны өдөр тутмын сонин болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр, 2017 оны 03 дүгээр сарын 31-ны өдөр дахин мэдээлэх, Монголын хөрөнгийн биржийн сайтад тавих, брокерийн компанид хүргүүлэх зэргээр хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсүгэй.

5. Хурлын зар өгөхтэй холбоотой зардлыг хурал зохион байгуулах комиссын дарга /Б.Баярсайхан/-д гаргаж өгөхийг компанийн санхүүд даалгасугай.

6. Ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь Хавсралт 1-д заасан бичиг баримтыг БДК-иудаас авч танилцах эрхтэй болохыг дурьдсугай.

7. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс энэхүү хурлаар хэлэлцэх асуудлаар саналын хуудсаар санал авах “саналын хуудас”-ны агуулгыг хавсралт 2-д зааснаар баталсугай.

8. Компанийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх асуудлаар санал авах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2017 оны 04 сарын 23-ны өдрийн 14 цагаар тасалбар болгосугай.

9. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хурал зохион байгуулах бөгөөд тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

- Б.Баярсайхан дарга
- Ю.Туяацэцэг гишүүн
- З.Оюунбилэг гишүүн

10. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комиссд даалгасугай. .

11. Хурал хуралдуулах тухай тогтоолыг гаргаснаас хойш 3 хоногийн дотор "Монгол секюритис" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл"-ийг Хавсралт 3-д заасан маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргэхийг хурал зохион байгуулах комиссын дарга /Б.Баярсайхан/-д даалгасугай.



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

[Handwritten signature]

/З.НОМУНДАРЬ /